



АУДИТЫН КОД: САГ-2018/05/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: .261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: Bayarmaao@audit.gov.mn

Аудитор С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	АУДИТЫН ХУРААНГҮЙ ТАЙЛАН.....	3
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	5
3	АУДИТЫН ТАЙЛАН	7
3.1	Оршил.....	7
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	7
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	7
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
3.5	Дотоод хяналт	9
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	9
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	10
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	10
3.9.1	Үндсэн хөрөнгийн талаар	10
3.9.2	Бүртгэл тайлагналын талаар	10
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	11
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	11
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	11
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	12
4.1	Үндсэн хөрөнгийн талаар.....	13
4.2	13
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	14
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5.6	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1029
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Б.ЦОГОО ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төрийн албаны зөвлөлийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG18.Docx



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3–т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.201\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG18.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Оршил

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд тус байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/ түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.


Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор О.Баярмаа, С.Отгонхорлоо нар хариуцаж хэрэгжүүлэв.

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 815 тоот албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төрийн албаны зөвлөлийн зорилго нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагад төрийн



үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх, иргэдэд ойр, уян хатан, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн бөгөөд идэвхи, санаачлагатай манлайлагч менежер бүхий төрийн албыг бэхжүүлэхэд оршино. Энэхүү зорилгыг хангаж ажиллахын тулд жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилтууд дэвшүүлж, чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж ирсэн байна.

Төрийн албаны зөвлөл нь төрийн албаны шинэтгэлийн стратеги зорилт, төрийн боловсон хүчний бодлогын хэрэгжилтийг хангах, зохицуулах, зохион байгуулах, төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийг нийгмийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн удирдах, төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлагыг хангасан боловсон хүчнээр төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах замаар Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

- Хүний нөөцийн хөгжлийн бодлого,
- Төрийн захиргааны хөгжлийн бодлого,
- Мэдээлэл хяналт шинжилгээ үнэлгээний бодлого,
- Стандартын удирдлагаар хангах гэсэн 4 зорилтын хүрээнд төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратегийн хэрэгжилтийг хангах, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль тэдгээрт нийцүүлэн гаргах хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсронгуй болгохтой холбогдсон зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн байна.

Төрийн албаны зөвлөл нь 15 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулдаг ба салбар нэгжгүй бөгөөд яамдын дэргэдэх салбар зөвлөл 11, аймаг нийслэл дэх салбар зөвлөл 22, агентлагийн дэргэдэх салбар зөвлөл 14 гэсэн гадаад бүтэцтэй ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль, эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Төрийн албаны зөвлөл нь тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Төрийн албаны зөвлөлийн асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 3 арга хэмжээ төлөвлөн тайлагнасан байна.

Төлөвлөсөн зарим арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар товчоолов. Тухайлбал,


- Салбар зөвлөл тус бүрийг мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний бодлого, хүний нөөцийн хөгжлийн бодлого стандартын удирдлагаар хангах;
- Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэжлийн шалгалт зохион байгуулах;
- Салбар зөвлөл төрийн албан хаагчдад зайны болон захиалгат сургалт зохион байгуулах зэрэг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй ажилласан байна.

Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Төрийн албаны зөвлөлийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд



үнэлснээс гадна Төрийн албаны зөвлөлийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 10 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Төрийн албаны зөвлөлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2014 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон, нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй нийцэж байгаа тул нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Төрийн албаны зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Төрийн албаны зөвлөлийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төрийн албаны зөвлөлийн бүтцэд бүртгэлээр тавих хяналтыг ажлын албаны дарга болон нягтлан бодогч нар хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Төрийн албаны зөвлөлийн 2017 онд хэрэгжүүлэх 4 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 730.6 сая төгрөг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэлээр урсгал зардалд 725.0 сая төгрөг буюу 99.2 хувийн биелэлттэй бөгөөд 5.6 сая төгрөгөөр хэмнэлттэй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар хэтэрсэн зардал байхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн бүрэлдэхүүн тайлангуудыг бүрэн бэлтгээгүй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Төрийн албаны зөвлөлийн дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “www.shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Төрийн албаны зөвлөл нь өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт;
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт,
4. Санхүүгийн тайлан;
5. Байгууллагын батлагдсан төсөв;
6. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл;
7. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Төрийн албаны зөвлөлтэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тайлант онд Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 78.0 сая төгрөгийн “Хүний нөөцийн системийн цөм хэсгийг хөгжүүлэх, нэвтрүүлэх” програм, 69.3 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, нийт 147.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл авах, хөрөнгийн зардлыг батлуулах, алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

3.9.2 Бүртгэл тайлагналын талаар

Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь цалингийн зардлыг мөнгөн гүйлгээний тайлангаас 80.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй, Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.



3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц бусад чухал асуудал илрээгүй болно.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим, сорил зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд нарийвчилсан горим, сорил төлөвлөж хэрэгжүүлэх зүйл байхгүй гэж үзлээ.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 228.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс: Нягтлан бодох бүртгэлийн 80.8 сая төгрөгийн алдааг залруулж, 147.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд менежментийн захидлаар 1 зөвлөмж өгөв.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төрийн албаны зөвлөлийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж 2017 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 866 тоот албан бичгээр ирүүлсэн болно.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 811.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь буюу 8.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажуулав. Өмнө нь тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төрийн албаны зөвлөлийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дугаар хэсэгт үзүүлэв.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стардарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Санхүүгийн хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

4.1 Үндсэн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 78.0 сая төгрөгийн "Хүний нөөцийн системийн цөм хэсгийг хөгжүүлэх, нэвтрүүлэх" програм, 69.3 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, нийт 147.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль, эрх зүйн актууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, алдааг давтан гаргахгүй ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,475.4	16,092.8
БАРАА МАТЕРИАЛ	15,475.4	16,092.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	190,702.0	288,458.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	190,702.0	288,458.4
Биет хөрөнгө	190,702.0	215,370.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	206,177.4	304,551.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,486.6	7,916.5
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,486.6	7,916.5
Өглөг	8,486.6	7,916.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	197,690.8	296,634.7
Засгийн газрын хувь оролцоо	197,690.8	296,634.7
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	434,739.6	434,739.6
Хуримтлагдсан үр дүн	-237,918.3	-138,974.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	869.5	869.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	206,177.4	304,551.2

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	580,035.1	910,061.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,845.2	179,450.0
Нийтлэг татварын бус орлого	81,845.2	179,450.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	498,189.9	730,611.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	584,717.4	811,117.7
УРСГАЛ ЗАРДАЛ	584,717.4	811,117.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	584,535.6	742,030.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,065.4	295,388.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,567.3	32,493.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,485.6	22,221.3
Хангамж, бараа материалын зардал	32,445.6	29,644.9
Эд хогшил, урсгал засварын зардал	342.1	0.0
Томилолт, зочны зардал	11,238.6	13,865.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,890.2	237,099.0
Бараа үйлчилгээний бусад зардал	106,500.8	111,318.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181.8	69,087.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-4,682.3	98,943.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	972.2	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,710.1	98,943.8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,401.0	0.0	201,401.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	201,401.0	0.0	201,401.0
Тайлант үеийн үр дүн	-3,710.1	0.0	-3,710.1
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,690.8	0.0	197,690.8
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	197,690.8	0.0	197,690.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	197,690.8	0.0	197,690.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	98,943.8	0.0	98,943.8
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,634.7	0.0	296,634.7

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	498,189.9	730,611.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	498,189.9	730,611.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	498,189.9	730,611.5
УРСГАЛ ЗАРДАЛ	498,189.9	730,611.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,008.1	662,468.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,065.4	295,388.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,567.3	32,493.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,445.8	22,221.3
Хангамж, бараа материалын зардал	28,318.8	29,684.4
Эд хогшил, урсгал засварын зардал	342.1	0.0
Томилолт, зочны зардал	12,560.8	13,865.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,882.2	237,099.0
Бараа үйлчилгээний бусад зардал	21,825.7	31,717.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181.8	68,142.6
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	730,611.5	725,074.1	5,537.4	99.2
УРСГАЛ ЗАРДАЛ	730,611.5	725,074.1	5,537.4	99.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	667,061.3	662,468.8	4,592.4	99.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,391.5	295,388.2	3.3	100.0
Үндсэн цалин	193,022.6	193,019.4	3.2	100.0
Нэмэгдэл	80,894.8	80,894.8	0.0	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	21,474.1	21,474.0	0.1	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,494.2	32,493.2	1.0	100.0
Тэтгэврийн даатгал	20,678.1	20,677.1	1.0	100.0
Тэтгэмжийн даатгал	2,954.1	2,954.1	0.0	100.0
ҮОМШӨ-ний даатгал	2,363.2	2,363.2	0.0	100.0
Ажилгүйдлийн даатгал	590.8	590.8	0.0	100.0
Эрүүл мэндийн даатгал	5,908.0	5,908.0	0.0	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,221.3	22,221.3	0.0	100.0
Байрны түрээс	22,221.3	22,221.3	0.0	100.0
Хангамж, бараа материалын зардал	29,684.4	29,283.0	(401.4)	104.7
Бичиг хэрэг	5,800.5	5,350.5	450.0	92.2
Тээвэр, шатахуун	17,349.8	17,944.1	(594.3)	111.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,807.0	5,988.4	(181.4)	103.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	727.1	401.4	325.7	55.2
Томилолт, зочны зардал	13,865.6	13,865.3	0.3	89.9
Дотоод албан томилолт	13,865.6	13,865.3	0.3	89.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	238,288.2	237,099.0	1,189.2	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,276.4	77,087.3	1,189.1	98.5
Даатгалын үйлчилгээ	107.0	106.9	0.1	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	277.2	277.2	0.0	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	19.8	19.8	0.0	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	159,607.8	159,607.8	0.0	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	35,116.1	31,717.6	3,398.5	90.3
Бараа үйлчилгээний бусад зардал	3,397.7	0.0	3,397.7	0.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,718.4	31,717.6	0.8	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,550.2	62,605.2	945.0	98.5
Бусад урсгал шилжүүлэг	63,550.2	62,605.2	945.0	98.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,750.2	58,750.2	0.0	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800.0	3,855.0	945.0	80.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	730,611.5	725,074.1	5,537.4	99.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	730,611.5	725,074.1	5,537.4	99.2



Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Улсын төсвөөс санхүүжих	730,611.5	725,074.1	5,537.4	99.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	39	39		100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
Төсвийн байгууллага	1	1		100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19		100.0
Удирдах ажилтан	3	3		100.0
Гүйцэтгэх ажилтан	15	15		100.0
Үйлчлэх ажилтан	1	1		100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19	19		100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	18	18		100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	1		100.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**